

# “ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС” ХХК-ИЙН САЛХИТЫН УУРХАЙН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЖИШИГ ТӨСЛИЙН МЭДЭЭ

Дугаар 15 2023 оны 1-р сар

## ■ ЖИШИГ ТӨСЛИЙН МЭДЭЭ: МОНГОЛ УЛСАД УУРХАЙН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ОЛОН УЛСЫН ШИЛДЭГ ТУРШЛАГЫГ НЭВТРҮҮЛЖ БАЙНА



Зураг 1. “Хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулах” багийн хэлэлцүүлэг 2023 оны 1 сарын 18 ба 20-ны өдрүүдэд боллоо.

Салхитын уурхайн Хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах жишиг төслийн гуравдугаар улирал 2022 оны 12 сард эхэлсэн билээ. Төлөвлөгөө ёсоор төслийн зөвлөх баг хаалтын төлөвлөгөөний бүлгүүдийг энэ улиралд багтаан бүрэн боловсруулж дуусгана. Үндэсний зөвлөхүүд, MERIT төсөл, “Си Пи Пи Энвайронментал” корпорацийн олон улсын зөвлөхүүдээс бүрдсэн төлөвлөлтийн баг хаалтын төлөвлөгөөг Монгол улсын холбогдох хууль тогтоомж, “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-ийн үйл ажиллагааны шаардлагад нийцүүлэхийн зэрэгцээ олон улсын тэргүүн туршлагаас тусган боловсруулж байна.

Жишиг төсөл нь олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх замаар Монгол улсын уурхайн хаалтын хууль, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулна. Энэ зорилгын хүрээнд УУХҮЯ, БОАЖЯ тэргүүтэй төрийн захиргааны төв байгууллагуудад уурхайн хаалтын бодлого, зохицуулалтыг хэрхэн сайжруулах талаар зөвлөмж хүргүүлнэ. Түүнчлэн, цаашид уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөг бие даан боловсруулах үндэсний зөвлөхүүдийн заавал эзэмшсэн байх шаардлагатай мэдлэг боловсрол, ур чадварын талаарх ойлголтыг төслийн оролцогч байгууллагуудад өгөх юм. Уурхайг хариуцлагатайгаар хаахад шаардлагатай зардал тооцооллын жишээг мөн гаргана.

Жишиг төсөл нь олон улсын тэргүүн туршлагыг тал бүрээр нэвтрүүлж байна. Тухайлбал уул уурхайн нөлөөгөөр эвдрэлд өртсөн газрыг хэлбэршүүлэх инженерийн зураг төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлдэг Канад улсын Газар Хэлбэршүүлэлтийн Хүрээлэнгийн тэргүүн туршлага, аргачлалыг ашиглан Салхитын уурхайн хаалтын газар хэлбэршүүлэлтийн инженерийн зураг төслийг боловсруулаад байна. Нөхөн сэргээлт, хаалтын дараах хяналт-шинжилгээний чиглэлээр нийт 4 удаагийн багийн хэлэлцүүлэг хийхээр төлөвлөснөөс 2 удаагийн хэлэлцүүлэг нь хаалтын дараах хяналт-шинжилгээний хөтөлбөр, шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулахад чиглэв.

Хаалтын төлөвлөгөөнд тусгаж буй олон улсын өөр нэг сайн туршлага бол уурхайн хаалтын зорилго, зорилт (зорилго, зорилт нь нийлээд хаалтын алсын харааг тодорхойлдог) болон шалгуур болон шалгуур үзүүлэлтийг (нөхөн сэргээлт, хаалтын хүрээг тодорхойлдог) эрэмбэ дараалалтай боловсруулах юм. Уг туршлагыг “Канадын Ойл Сэндс” групп ашигладаг бөгөөд олон улсад нэвтрүүлэх ажлыг Олон Улсын Уул Уурхай, Металлын Зөвлөл хийдэг. Түүнчлэн, үндэсний зөвлөх багууд төслийн хүрээнд хэрэгжүүлсэн чадавх бэхжүүлэх сургалтуудад хамрагдаж олон улсад хэрэгжиж буй уурхайн хаалтын сайн туршлагын талаар мэдлэг ойлголт авч, шаардлагатай ур чадварыг эзэмшсэнээр цаашид ижил төстэй төсөл дээр ажиллах чадавх бүрдэж байна. Төслийн хүрээнд нутгийн ард иргэдийн оролцоог хангах, саналыг сонсох үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа нь төлөвлөлтийн баг болон төслийн оролцогч талуудад иргэдийн оролцоо, хамтын ажиллагааг хангах үйл ажиллагааг эртнээс сайн төлөвлөн хэрэгжүүлснээр уул уурхайн компаниуд иргэдийн дэмжлэгийг авч үйл ажиллагааг явуулахад чухал нөлөөлтэй болохыг харуулсан юм. Энэ нь төрийн байгууллага, оролцогч талуудад уурхайн хаалт болон хаалтын дараах шилжилтийн үе шатууд дахь нийгэм-эдийн засгийн шилжилт, иргэдийн асуудлын хамрах цар хүрээ, олон янзын нөхцөл байдлыг ойлгоход чухал туршлага боллоо.

## ■ ГУРВАНСАЙХАН СУМЫН ИРГЭДЭД УУРХАЙН ХААЛТ, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ШИЛЖИЛТИЙН ТАЛААР МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ ӨГӨХ СУРГАЛТ



Зураг 2. Гурвансайхан сумын иргэд сургалтад хамрагдав.

Төслийн нийгэм-эдийн засаг, жендэрийн зөвлөх баг 2023 оны 1-р сарын 16-ны өдөр Дундговь аймгийн Гурвансайхан суманд ажиллаж, иргэдэд уурхайн хаалт, хаалтын төлөвлөгөөний зорилго болон нийгэм-эдийн засгийн шилжилтийн талаар мэдээлэл өгөх, иргэдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгууллаа.

Сургалтад Чулуут баг болон бусад багийн иргэд, малчдын төлөөлөл нийт 40 хүн оролцов. Иргэд багт хуваагдан ажиллаж, Салхитын уурхайн хаалт, нөхөн сэргээлт, хаалтын дараах газар ашиглалт, нийгэм-

эдийн засгийн шилжилтийг төлөвлөхөд тусгах саналаа хэлэлцэж нэгтгэв. Мөн уурхайн хаалтын үйл явцад хэрхэн оролцох талаар өөрсдийн саналыг хуваалцав.

## САЛХИТЫН УУРХАЙН ХААЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЖИШИГ ТӨСӨЛ: ИРГЭД УУРХАЙТАЙ ТАНИЛЦАХ ӨДӨРЛӨГ

Салхитын ордын Хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах төсөлд иргэдийн оролцоог хангах хоёр дах удаагийн уулзалт, зөвлөлдөх арга хэмжээг Эрдэнэс Силвер Ресурс (ESR) ХХК-ийн Салхитын уурхайд 2023 оны 1-р сарын 25-ны Лхагва гарагт амжилттай зохион байгуулав. Нөлөөлөлд өртөж буй иргэдийн санал хүсэлтийг хаалтын төлөвлөлтөд тусгахад жишиг төслийн зүгээс ихээхэн анхаарч, мэдээлэл өгөх сургалт, сурталчилгааны арга хэмжээ болон зөвлөлдөх уулзалтуудыг үе шаттай зохион байгуулж байна.

Уурхайтай танилцах уг арга хэмжээнд нөлөөлөлд өртсөн иргэд буюу Чулуут багийн малчид, Гурвансайхан сумын ИТХ-ын төлөөлөгчид, сумын захиргааны албан хаагч зэрэг нийт 75 хүн хамрагдлаа. Энэхүү арга хэмжээний үеэр шимт хөрсний менежмент, дахин ургамалжуулалт ба газар хэлбэршүүлэлт зэрэг хаалтын нөхөн сэргээлт хийхтэй холбоотой ерөнхий төлөвлөлтийг оролцогчдод танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлэв. Мөн өнгөрсөн оны 9 дүгээр сард зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийн үеэр иргэдээс өгсөн саналын үр дүнг танилцуулж, Салхитын ордын хаалтын төлөвлөлтөд хэрхэн тусгаж буй талаар тайлагнав.



Зураг 3. Иргэд уурхайн байгууламжуудтай танилцав.



Зураг 4. Иргэдэд мэдээлэл өгч, хэлэлцүүлэг өрнүүлэв.

Хэлэлцүүлгээр Хаалтын дараах газар хэлбэршүүлэлт буюу эвдрэлд өртсөн уурхайн байгууламжуудад техникийн нөхөн сэргээлтийн төлөвлөлт хэрхэн хийх тухай инженерийн зураг төслийг боловсруулах ач холбогдлыг иргэдэд ухуулан таниулж, санал солилцов. Урт хугацаанд, аюулгүй, тогтвортой экосистемийн тогтолцоо бүхий хаалтын нөхөн сэргээлт хийх талаар компани болон иргэдийн нэгдсэн ойлголтыг бэхжүүлж, иргэдэд нээлттэй мэдээлэл өгч, мэдлэгийг нэмэгдүүлэхэд уг арга хэмжээний ач холбогдол оршиж байв.

“Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-ийн зүгээс нөхөн сэргээлт хийх үүрэг хариуцлагаа баталгаажуулсан, нутгийн ард иргэдтэй эерэг харилцаа тогтоох чиглэлээр дэвшилт гаргасан чухал уулзалт боллоо хэмээн иргэд, оролцогчид дүгнэж байв.

Мөн энэ хүрээнд Уурхайн хаалтын талаар сурагчдын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор “Салхитын уурхай хаагдсаны дараа –Бидний төсөөллөөр” сэдэвт эсээ бичлэг, гар зургийн уралдааныг Гурвансайхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулсан юм. Тус уралдаанд тэргүүлсэн сурагчдын шагналыг Эрдэс Силвер Ресурс ХХК болон MERIT төслийн төлөөлөл 1-р сарын 24-ны өдөр гардуулан өглөө.



Зураг 5. Гар зургийн уралдаанд тэргүүн байр эзэлсэн 12 дугаар ангийн сурагч Д.Дугармаагийн бүтээл.



Зураг 6. Энэ сарын 24-нд уралдаанд тэргүүлсэн сурагчдыг “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК шагнаж урамшууллаа.

## ТӨЛӨВЛӨЛТИЙН БАГ ХАГАС ЖИЛИЙН АЖЛАА ДҮГНЭЛЭЭ

Өнгөрсөн оны 6-р сард эхэлсэн Салхитын уурхайн Хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах жишиг төсөл (II шат) эхний хагас жилийн ажлаа дүгнэлээ. 2023 оны 1-р сарын 11-ний өдөр болсон тус уулзалтаар төлөвлөлтийн баг өнгөрсөн хугацааны ололт амжилт, сургамжаа нээлттэй хуваалцаж, дараагийн хагас жилд ажиллах арга барилаа тодорхойлох, багийн бүтээмж үр дүнг сайжруулах талаар санал солилцов.

### 2-Р САРД ХИЙХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН АЖЛУУД:

- 2023.02.07: Оролцогч талуудын зөвлөлдөх уулзалт
- 2023.02.08: “Хаалтын өртөг зардал тооцоолох” хэлэлцүүлэг
- 2023.02.01, 14: “Хаалтын дараах хяналт шинжилгээ, мониторинг” хоёр удаагийн багийн хэлэлцүүлэг

### Ашигласан материал

Landform Design Institute. Undated. Our Mission. <https://www.landformdesign.com/> (Retrieved January 22, 2023)

## ХОЛБОО БАРИХ

Бид та бүхэнд Салхитын уурхайн хаалтын мэдээ мэдээллийг аль болох сонирхолтой байдлаар хүргэхийг зорьдог билээ. Төслийн оролцогч талуудын санал, сэтгэгдлийг сонсож, бэлтгэж буй мэдээ мэдээллийг уншигчдын хэрэгцээ, сонирхолд нийцүүлэх нь чухал юм. Тиймээс та бүхэн төслийн сар тутмын мэдээтэй холбоотой санал сэтгэгдлээ бидэнтэй хуваалцана уу.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Төслийн захирал  
**Р.Алтангэрэлтэй** имэйл хаягаар холбогдоно уу.  
[r.altangerel@merit.mn](mailto:r.altangerel@merit.mn)